

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2025 ОНД БАЙГУУЛСАН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТЫН ХЭРЭГЖИЛТ
/2025 оны жилийн эцсийн байдлаар/**

2025 оны 12 сарын 10

Өлгий сум

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.							
3.1.1	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах;		Угийн бичгийн хөтлөлтийн хувь	2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт	Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна.	Угийн бичих хөтлөлтийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд: 1. Угийн бичиг хөтлөх, түүний ач холбогдлын талаар монгол, казах хэл дээр бэлтгэсэн 2 төрлийн ТВ нэвтрүүлгийг байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээн ажиллалаа. Нийт хандалтын тоо 25615 байна. 2. Байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран Гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион явуулж “Гэр бүлийн үнэт зүйл, ургийн бичиг” сэдвийн хүрээнд мэдээлэл өгч ажилласан. Нийт 713 хүнийг хамруулсан байна. 3. Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтын нэг болох “Гэр бүлийн үнэт зүйл, ургийн бичиг” сэдэвт цахим хичээлийг байгууллагын цахим хуудсаар түгээн ажилласнаар нийт хандалтын тоо 5678 байна. 4. Угийн бичиг хөтлөх, түүний ач холбогдлыг ойлгуулах зорилгоор, дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Удам судраа мэдэж, угийн	Хэрэгжсэн

						бичгээ хөтөлцгөө” сэдвийн хүрээнд цахим уралдаан, “Миний угийн бичиг-Миний бахархал” сэдэвт илтгэлийн уралдаан, 4 төрлийн сургалтыг тус тус зохион байгуулсан ба нийт 188 хүүхэд оролцсон. 5. Угийн бичгийн дэмжин туслах багшаар ахмад багш нарын төлөөллөөс 2 багшийг ажиллуулан иргэдэд зөвлөгөө өгөх, контент бэлтгэн цахимаар түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласны үр дүнд угийн бичгийн хөтлөлтийн хувь аймгийн хэмжээнд 90 хувьтай байна.	
--	--	--	--	--	--	--	--

3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:

3.1.2.1	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	20,700.00	1. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө -1 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн илрүүлэлтийн хувь	2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо-375	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	Аймгийн ИТХ-ын 2022 оны тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрийн батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 26 удаагийн сургалтыг зохион явуулж давхардсан тоогоор нийт 2690 хүнийг хамруулсан. Мөн Аймгийн ШШГГазартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхээр баривчлагдсан иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, хувь хүний хөгжлийн мэдлэг, ойлголт олгох сургалтуудыг тогтмол 7 хоног бүрийн 2 өдөр зохион явуулж 396 хүнийг хамруулсан байна. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд, сум, багийн Хамтарсан багийн гишүүдтэй хамтран сум, багуудын архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай, гэр	Хэрэгжсэн
---------	--	-----------	--	---	--	--	-----------

						<p>бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй гэр бүлүүдээр эргэн хяналтаар ажиллаж, нөхцөл байдлын болон хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.</p> <p>Урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ авч ажилласнаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл өмнөх оноос 116 нэгжээр буюу 30 хувиар, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг 6 нэгжээр буюу 17.1 хувиар тус тус өссөн нь иргэдийн гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, мэдлэг нэмэгдсэнтэй холбоотой юм.</p>	
3.1 2.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.		<p>1. Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p> <p>2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь</p>	2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо 8	<p>Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна.</p>	<p>Гэр бүлийн хөгжлийг дэмжиж гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өөрийгөө хайрлахуй”, “Хос багана”, “Эрчүүдийн яриа”, “Гэр бүлийн хөгжилд бидний оролцоо”, “Гэр бүлээрээ гэрэлтэй”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Эерэг харилцаа-Эрүүл гэр бүл”, “Гэр бүлийн соёл-Нийгмийн баялаг”, “Ээж охины болзоо” зэрэг 10 төрлийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 1346 хүнийг хамруулсан бол Олон Улсын Гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн үнэ цэнэ, хайр” өдөрлөг, Хүүхдийг зодож шийтгэхгүй байх олон улсын өдрийг тохиолдуулан “ХҮҮХДЭЭ ХАЙРЛАН ХАМГААЛЪЯ” өдөрлөгийг зохион байгуулж 20 байгууллагын 440 хүнийг хамруулсан байна. Түүнчлэн байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран Хүүхэд хүмүүжлийн зэрэг аргыг түгээн дэлгэрүүлэх,</p>	Хэрэгжсэн

						гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион явуулж, нийт 89 байгууллагын 4701 хүнийг хамруулсан бол аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүлжүүлэгдсэн иргэдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтыг долоо хоногт 2 удаа тогтмол зохион байгуулж 396 хүнийг хамруулсан байна.	
3.1. 2.3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо		Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролы н хүртээмж, чанар сайжирна.	2023 оноос ГХУСАЗСЗөвлөлийн дэмжлэгтэйгээр Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг тохижуулан, 2024 оны 10 сараас Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт сэтгэл зүйчийн орон тоог бий болгож, мэргэжлийн сэтгэл зүйч томилон ажиллуулж байна. 2025 оны байдлаар давхардсан тоогоор нийт 10150 хүнд гэр бүлийн болон амьдрах ухааны боловсрол, сэтгэл зүй, эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэн, 353 хүнд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөөгөөр дамжуулан үзүүлсэн байна.	Хэрэгжсэн

3.1. 2.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	2024 онд баталсан төсөв 10 сая	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	2024 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сум, баг тус бүрд Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд ажиллаж эхэлсэн. Хуулийн шинэчилсэн найруулгаар Хамтарсан багийн нарийн бичгээр хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд ажиллах зохицуулалт орсон Хамтарсан багийн өмнөх гишүүд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бүх Хамтарсан багуудыг шинэчлэн байгуулж, тушаал, захирамж гаргуулсан. 2025 оны байдлаар сум, орон нутгийн төсвөөс нийт 8 сумын Хамтарсан багийн үйл ажиллагаанд зориулж 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн шатны ИТХ-д оруулан шийдвэрлүүлсэн байна. Хамтарсан багууд нийт 5208 хүнд хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээг үзүүлж, өндөр эрсдэлтэй 327 тохиолдолд кейс нээж ажилласан байна. Урьдчилан сэргийлэх чиглэлээр 57 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 6846 хүнийг хамруулсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг түр хамгаалах байрны урсгал зардалд орон нутгийн төсвөөс 20 сая төгрөг шийдвэрлэн үйл ажиллагаагаа тогтмол үзүүлэх боломжоор ханган ажилласан. 2025 оны байдлаар Нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 43 хүн үйлчлүүлсний 10 нь насанд хүрэгч 33 нь хүүхэд байна.	Хэрэгжсэн
3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:							

3.1. 3.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;	1,758,43 1.10	1 Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжил, оролцоог дэмжих асуудлаар цаг тухай бүр шуурхай арга хэмжээ авч, салбар дундын уялдаа холбоог сайжруулж ажлын хуваарилалтыг хийх, хүүхдийн хөгжил хамгааллын салбар бүрд эрчимжүүлж, үр дүнг үнэлэх, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээний чанар, арга зүйг сайжруулахад чиглэлээр аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Боловсролын газартай хамтарсан төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү төлөвлөгөөний дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хариу үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, байгууллага бүр өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэх, цаг тухайд нь мэдээлэл солилцох, хамтран зохион байгуулалт хийх зэрэг ажилд ахиц гарч, салбар бүр хүүхэд хамгааллын ажилд онцгой анхаардаг болсон. төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны байдлаар 85 хувьтай үнэлэгдлээ.	Хэрэгжсэн
3.1 3.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;		Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	2024 онд хамрагдсан хүүхдийн тоо 1245	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна.	Хүүхдийн хөгжил, авьяасыг чадварыг дэмжих ажлын хүрээнд хөгжлийн дугуйлан, уулзалт хэлэлцүүлэг, зуслангийн хөгжлийн хөтөлбөр, зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 1425 хүүхэд хамрагдсан байна. Үүнд: - Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх "Хуралай" бүжгийн дугуйланд Өлгий, Баяннуур, Алтанцөгц, Улаанхус сумдын 412 хүүхэд хамрагдаж суралцсан. - Олон улсын чанартай 5 удаагийн тэмцээнд 182 хүүхдийн оролцоог хангаж, дэмжлэг үзүүлснээр Казахстан, Узбек, ОХУ зэрэг	Хэрэгжсэн

				<p>орнуудад очсон байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Олон улсын бүжгийн “Би алем-2025” тэмцээнд нийт 320 хүүхэд оролцсон бол Домборын дугуйланд нийт 100 хүүхэд хамрагдсан байна.</p> <ul style="list-style-type: none">- Юнител компани санхүүжилтээр байгуулагдсан “Unitel Hub” төвд шатар, англи хэл, робо-кид, электро-кид, дрон, кодчиллол зэрэг нийт 5 төрлийн сургалтууд явагдаж 180 гаруй хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулсан.- Хүүхэд багачуудын технологийн боловсролыг дэмжихийн зэрэгцээ, ухаалаг тоног, төхөөрөмж хэрхэн бүтээгддэгийг ойлгох, анхан шатны мэдлэг олгох “техник спортын” дугуйланд 19 хүүхэд хамрагдсан.- Зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг 4 удаа зохион байгуулж 267 хүүхдийг оролцуулсан.- Аймгийн хэмжээнд нийт 23 удаагийн уралдаан, тэмцээнд 1005 хүүхдийг тус тус хамруулсан байна.- НҮБ-ийн хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Хөгжмийн танхим, “Ирээдүйн долгион” хүүхдийн подкаст студи нээн ажиллуулж, тус төвөөр дамжуулан 45 хүүхдэд хөгжмийн боловсрол, техникийн ур чадвар олгож байна. <p>Хүүхдийн хөгжлийг дэмжих дугуйлан, сургалтууд, олон улсын арга хэмжээнд хүүхдүүдийг оролцуулахад 20,2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож дэмжин ажилласнаар хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 30 хувиар өссөн байна.</p>
--	--	--	--	---

3.1. 3.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;		Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв 0	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтэд санхүүжилт шийдвэрлэгдээгүй ч холбогдох байгууллагууд хариуцсан ажлуудаа өөрийн санхүүгийн болон хүний нөөцийг ашиглан хийж хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөнд 28 арга хэмжээ тусгаснаас бүрэн хэрэгжсэн 22, хэрэгжих шатандаа байгаа 4, хэрэгжээгүй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт 80 хувьтай байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, хөгжлийг дэмжих үйлчилгээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 11.5 сая төгрөгийг шийдвэрлэн зарцуулсан байна.	Хэрэгжсэн
3.1. 3.4.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;		1. Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/		Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага, аж ахуйн нэгж одоогоор байхгүй байна.	Хэрэгжээгүй
3.1 3.5.	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр		Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	0	Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа	Хүүхдийн оролцооны байгууллага болох аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл 2025 онд нийт 38 хүүхдийн бүрэлдэхүүнтэй, 12 сум тус бүрд салбар зөвлөлтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрх зөвлөл тогтмол, үйл ажиллагаа явуулах боломжоор хангах	Хэрэгжсэн

	<p>гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;</p>				<p>сайжирсан байна.</p>	<p>үүднээс орон байртай болгож урсгал зардлыг бүрэн шийдвэрлэсэн. Үүний үр дүнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Хүүхдийн зөвлөлийн санал, санаачилгыг дэмжих, оролцоог хангах зорилгоор тус зөвлөлтэй хамтран сургалт, нөлөөллийн ажил, хөгжил, оролцооны арга хэмжээ, чадавхжуулах хөтөлбөр, тэмдэглэлт өдрүүдийг угтсан үйл ажиллагаа, уулзалт хэлэлцүүлэг, зөвлөгөө мэдээлэл өгөх өртөөчилсөн арга хэмжээ зэрэг 15 төрлийн үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 8 цахим контент хийж цахим орчноор олон нийтэд түгээж ажилласан байна.</p> <p>-Аймгийн хүүхдийн зөвлөлийн сурагчид “Мини парламент”-ын гишүүнээр элсэн “Ховд голоос миний амьдрал эхтэй” мини хуралдааныг анх удаа аймагтаа зохион байгуулж аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн зөвлөлийн тэргүүнд хуралдаанаас гарсан 10 төрлийн саналыг уламжилсан байна.</p> <p>- Хамтын ажиллагааны хүрээнд НҮБ-ийн хүүхдийн сангаас дэмжлэг авч аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах “Тэгш оролцоо-хязгааргүй боломж” сургалтад аймаг, сумдын хүүхдийн зөвлөлийн идэвхтэн гишүүдийг хамруулан ажиллалаа. Дээрх үйл ажиллагаануудад давхардсан тоогоор нийт 1310 гаруй хүүхэд хамруулж улсын төсвөөс 50,0 сая төгрөг зарцуулсан байна.</p>
--	---	--	--	--	-------------------------	--

<p>3.1. 3.6.</p>	<p>“Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.</p>		<p>1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо</p>		<p>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газартай хамтран Хүүхэд хамгаалагч нэг хүнийг авч ажилласан. Түүнчлэн Хүүхдийн эрхийн улсын байцаагч 1 байсныг нэмэгдүүлэн шинээр 3 албан тушаалтныг байцаагчаар сургаж 4 албан тушаалтан байцаагчийн эрхтэйгээр ажиллаж байна.</p> <p>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийг сайжруулж, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах ажлын хүрээнд 13 сумын Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд зорилтот айлуудаар орж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх ажлыг жилийн турш 8 үе шаттай зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 13 сумын нийт 2780 өрхөд гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, 3355 хүүхдэд хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийж, үүнээс эрсдэлтэй хэмээн үнэлэгдсэн нийт 2247 хүүхдийг эрсдэлийн программд бүртгэн, 327 хүүхдэд кейс нээн ажилласан байна. Нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, зан авир, танин мэдэхүй, нийгэмшихүй, боловсролын байдал, гэр бүл, сургалтын орчин, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд өсгөх ур чадвар, тэдний хоорондын харилцаа зэрэг нөхцөл байдлыг нягтлан судлахыг зорин ажилласан байна. Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн өрхүүдийн 1853 хүнд гэр бүлийн харилцаа, ёс зүй, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, 213 хүнд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлсэн байна.</p>	<p>Хэрэгжсэн</p>
----------------------	---	--	---	--	--	------------------

				<p>Эрсдэлийн программд бүртгэгдсэн дээрх 2247 хүүхдэд харьяа багийн хамтарсан багийн хамт хяналтад авч шаардлагатай хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх ажил төлөвлөгөөний дагуу шат дараатай явагдсан бөгөөд тус газраас 2 удаа эргэн хяналт хийх ажлыг зохион байгууллаа. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 65 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>
--	--	--	--	--

				<p>Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийх, илрүүлэлтийг сайжруулах ажилд улсын төсвөөс 9,0 сая төгрөг зарцуулсан ажилласнаар Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 65 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>
--	--	--	--	--

3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:

.1.4 1.	“Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;	507,011.60	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	123	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна	<p>2025 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 137 Эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаа явуулж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь аймгийн хэмжээний нийт байгууллагын 85 хувийг эзэлж байгаа юм. Тус онд төрийн байгууллагад 3, аж ахуйн нэгж байгууллагад 5, нийт 8 Эцэг эхийн зөвлөл шинээр байгуулагдаж, 14 байгууллага шинээр Хүүхэд хамгааллын бодлогоо батлуулан хэрэгжүүлж байгаа бол хүүхдийн өрөө тохижуулан ашиглалтад өгсөн 5 байгууллага байна.</p> <p>Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн ажлыг эрчимжүүлэх, удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:</p> <p>1. Байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Жендерт суурилсан хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллага, сургууль, цэцэрлэгүүдийн дунд “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд таны оролцоо” нөлөөллийн аян зарлан аяны хүрээнд “Цагаан хавтас” аялуулан 64 байгууллагын 1471 хүнийг хамруулан хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.</p> <p>2. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдийн дунд “Гэр бүлийн үнэ цэнэ” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж 58 байгууллагын 1276 хүнийг хамруулсан байна.</p>	Хэрэгжсэн
------------	---	------------	--	-----	---	--	-----------

					<p>3. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний үеэр 10 сумын төрийн болон төрийн бус байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж нийт 190 хүнийг хамруулсан.</p> <p>4. Байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран Гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион явуулж, нийт 3346 хүнийг хамруулсан байна.</p> <p>5. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөлийн талаар 1 удаагийн видео хичээл, 4 төрлийн постерийг түгээн ажилласан байна. Нийт хандалтын тоо 6413 байна.</p>	
--	--	--	--	--	---	--

1.4. 2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	825	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагат ай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	<p>Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээг шаардлагатай хүүхэд бүрд хүргэх зорилгоор хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь тогтоогдсон өндөр эрсдэлтэй хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төлөвлөгөө гаргаж жилийн турш 941 хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, 6182 хүүхэд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээ үзүүлэх ажлыг тус тус хийсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 92 хувиар эрс өссөн үзүүлэлт болно. Кейс менежмент, нийгмийн мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг төрлөөр нь задалбал дараах байдалтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд 2780 өрхөд анхан шатны гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, 3355 хүүхэд эрсдэлийн үнэлгээ, 1135 хүүхдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж, асуудлыг нь бүрэн шийдвэрлэсэн 307 тохиолдол байна. - Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 327 хүүхэд хамрагдсан ба энэ үйлчилгээг 297 хүүхэд, гэр бүлийн орчинд, 33 хүүхэд гэр бүлээс тусдаа орчинд буюу аюулгүй байдлыг хангах үйлчилгээнд хамруулсан байна. - Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан 6182 хүүхдээс хөгжлийг дэмжих үйлчилгээнд 1037 хүүхэд, сургалтын үйл ажиллагаанд 2561, нөлөөллийн ажилд 2584 хүүхдийг, дугуйлан, өөрийгөө хөгжүүлэх 	Хэрэгжсэн
------------	--	--	-------------------------------------	-----	---	---	-----------

					<p>үйлчилгээнд 170 хүүхдийг тус тус хамруулжээ.</p> <p>Дээрх хариу үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдүүдийн 63% нь эмэгтэй хүүхэд байгаа бол 119 нь хөгжлийн ялгаатай хүүхэд, 145 нь бүтэн өнчин хүүхэд, 58 нь үрчлэгдсэн хүүхэд байгаа болно.</p> <p>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх ажилд улсын төсвөөс 60,0 сая төгрөг зарцуулагдсан байна.</p>	
--	--	--	--	--	---	--

.4.3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;		1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь	26.7 хувь	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	2025 оны байдлаар нийт 49 хүүхэд Хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан бөгөөд эдгээр хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор 1 удаа хуралдаж холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан. Хорооны гишүүдийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг танилцуулах сургалтад бүрэн хамруулж, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүрэг, хэрэгжүүлэх арга зүйн талаар мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч дээрх 49 хүүхдэд давхардсан тоогоор дараах үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд: Нөхцөл байдлын үнэлгээг - 49 хүүхдэд, Хууль эрх зүй, өмгөөллийн үйлчилгээг 40 хүүхдэд, Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг -30 хүүхдэд, Нэг цэгийн үйлчилгээнд хамруулж аюулгүй байдлыг хангах үйлчилгээг 13 хүүхдэд, Хүүхдийн хөгжил оролцоог хангах үүднээс төрөл бүрийн сургалт дугуйланд 6 хүүхдийг тус тус хамруулан ажиллалаа. 2025 онд шинээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 хүүхэд бүртгэгдсэн бол өмнөх оноос үргэлжилж байгаа 14 хүүхэд нийт 17 хүүхдэд Зан үйлээ засах сургалт, Гэрээр нь очиж засрал хүмүүжлийн байдалтай нь танилцаж зөвлөгөө өгөх үйлчилгээг хүргэн ажилласан. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгоор сайн дурын ажилд 15 хүүхдийг, өөрийн оролцооны клубийн үйл ажиллагаанд 5 хүүхдийг, Англи хэлний дугуйланд 3 хүүхдийг, шатрын дугуйланд 3 хүүхдийг, роботын дугуйланд 2 хүүхдийг, Герман	Хэрэгжсэн
-------	---	--	--	-----------	---	---	-----------

					<p>хэлний дугуйланд 1 хүүхдийг тус тус хамруулсан байна.</p> <p>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг арга, өсвөр насны хүүхэдтэй ажиллах арга зүй, гэр бүлийн харилцаа сэдвээр нийт 3 удаагийн сургалт, 40 хүнд ганцаарчлан зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Мөн аймгийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран эцэг эхчүүдэд зориулсан 2 удаа нөлөөллийн ажил зохион байгууллаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдүүдийн эрхийг хангах ажилд улсын төсвөөс 10 сая төгрөг орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөг батлуулан зарцуулсан.</p>	
--	--	--	--	--	--	--

.4.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амьнас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих,		1 Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь		Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. Аймгийн төв болон сумын хэмжээнд зохион байгуулагдсан хурдан морины уралдаанд уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих стандарт шаардлагын дагуу хяналт тавьж, аюулгүй байдлыг хангуулах ажил аймгийн төвд 4 удаа, сумдад 10 удаа зохион байгуулагдлаа. Нийт 14 удаагийн хурдан морины уралдаанд оролцсон 416 уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, гэнэтийн ослын даатгал, эцэг эхийн зөвшөөрөл, гэрээ, морины хэрэгсэлд хяналт тавьж ажиллаа. Энэ ажлын үр дүнд уралдаануудад хамгаалалтын хувцас өмсөж уралдах, даатгал хийлгэх, уралдаанч хүүхдийн эцэг эхээс нь зөвшөөрөл авах зэрэг ажлууд жигдэрч ямар нэгэн зөрчил гараагүй болно. Жилийн турш 14 удаагийн хяналт тавих ажлыг хийж, 4 зөрчлийг газар дээр нь арилгах арга хэмжээ авч ажилласан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь шийдвэрлэн ажиллаж улсын төсвөөс 3.8 сая төгрөг зарцуулсан байна.	Хэрэгжсэн
-------	--	--	--	--	---	-----------

1.4.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;		1.ҮЙЛЧИЛГЭЭ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	М№ 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	Хэрэгжсэн
					“Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журмын хэрэгжилтийг хангах, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газраас ирсэн зөвлөмж, төлөвлөгөөний дагуу урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээг 2 үе шаттай зохион байгууллаа. Эхний ээлжид “Ган зудын эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу үнэлгээ хийх, бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын хүүхэд хамгааллын мэргэжлийн анги гамшгийн үеийн хүүхэд хамгааллын чиглэлээр сум бүр төлөвлөгөө, зураглал гаргах ажил хийгдсэн. Энэхүү ажлын үр дүнд үндэслэн сум, баг бүрд урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлэв. Үүнд: - Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний үеэр гамшгийн болзошгүй эрсдэлийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах, хуулиараа хүүхдүүд гамшгийн үеэр эдлэх эрхийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Давхардсан тоогоор гамшиг, онцгой байдлын чиглэлээр 500 хүүхэд, 250 насанд хүрэгч мэдээлэл, арга зүйгээр хангагдсан байна. - Мөн цахимаар 8 удаа сэрэмжлүүлэх постер, 2 удаа хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөгөө өгч ажилласан болно. - Зудын үеэр өндөр эрсдэлтэй сумын иргэдэд тухайн сумын Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, арга зүйгээр хангах ажилд 480 хүнийг хамруулсан байна.	

						<p>- Мөн цахилгааны гэмтлийн улмаас байшин нь шатсан 2 өрх, гэр нь салхинд хийссэний улмаас орон байргүй болсон 14 өрхийн 31 хүүхдэд гамшиг онцгой байдлын үеийн хариу үйлчилгээ үзүүлж, шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>- Баруун бүсийн гамшиг онцгой байдлын үеийн бэлэн байдлын команд штабын "Сөргө" дадлага, сургалтад Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн 15 албан хаагч хамрагдаж эрсдэлийг даван туулах, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх, хүүхэд, гэр бүл, олон нийтийг хэрхэн дэмжих зэрэг мэдлэг, ойлголттой болсон байна.. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын зардал болон сургалт нөлөөллийн ажилд улсын төсвөөс 40 сая төгрөг зарцуулсан ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	--	--

1.4.6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худагорчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;		Осол гэмтлийн буурсан хувь		<p>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.</p> <p>Аймгийн төвийн 14 хүүхдийн тоглоомын талбай болон орон сууцны орчны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт хийж, эвдрэлтэй гэрэлтүүлэг, ил задгай утас зэрэг нийт 12 зөрчлийг илрүүлэн холбогдох байгууллагад мэдэгдэж, 12 эрсдэл бүхий нөхцөл байдлыг засах арга хэмжээ авхуулсан байна. Замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худгийн орчимд хяналт шалгалт хийж, аюултай 6 байршилд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулсан, 3 байршилд нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна.</p> <p>Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад нийт 4 зөвлөмж хүргэгдэж ажилласан байна. "Асуудал-Шийдэл" аяны хүрээнд аймгийн төв болон сумдад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж талбайн болон айл өрхийн ойр орчимд ухсан нүх, суваг шуудуу, худаг орчимд хяналт шалгалтын ажил зохион байгуулсан. Тус шалгалтад 161 айл өрх хамрагдсан ба айл өрхийн ойр орчимд илэрсэн эрсдэлийг арилгах ажил 80 хувьтай үргэлжилж байна.</p>	Хэрэгжсэн
--------	--	--	----------------------------	--	--	-----------

.1.4. 7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь		Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/17 дугаар тушаалаар батлагдсан Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 онд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан. Тус төлөвлөгөөний дагуу 6 удаагийн хяналт шалгалтад 90 объектыг хамруулсан. Үүнээс төлөвлөгөөт хяналт шалгалтад 71 объектыг хамруулсан бол, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 4 объектыг, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 15 объектыг хамруулан зөрчилтэй ажиллаж байгаа 13 газарт албан шаардлага хүргүүлсэн бол эрсдэл гарч болзошгүй байгаа 10 газарт зөвлөмж өгч хэрэгжилтийг нь хангуулан ажилласнаар хүүхдийн эрхийн зөрчил гараагүй болно. Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын ажил, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулах ажилд 2,2 сая төгрөг зарцуулан ажилласан.	Хэрэгжсэн
-------------	--	--	-------------------------------------	--	---	--	-----------

3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;

3.2. 1.1.	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан	1,816,61 1.50	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Хөдөлмөрийн тухай хууль, дагаж гарсан дүрэм, журмын талаар 69 ажил олгогч байгууллагын 1457	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт	Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлан таниулах ажлын хүрээнд аймгийн төвийн 68 аж ахуйн нэгж, байгууллагын 823 иргэн, Сагсай, Цэнгэл, Ногооннуур, Цагааннуур сумдын 14 аж ахуйн нэгж, байгууллагын 258 иргэн, нийт 82 байгууллагын 1081 ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулж, хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн талаар 350 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.	Хэрэгжсэн
--------------	--	------------------	--------------------------------	---	--	--	-----------

	таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;			ажилтан, 268 сонирхогч этгээдэд мэдээлэл өгсөн.	сайжирсан байна.		
3.2. 1.2.	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;		1 .Хамрагдсан ААН байгууллагын тоо 2. Зохион байгуулсан сургалтын тоо	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг 4 аж ахуйн нэгж байгууллага д 1 зөвлөх багш, 1 мэргэжилтэн хэрэгжүүлэн ажиллаж, 4.4 сая төгрөг зарцуулсан.	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна.	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн талаар 50 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлэл хүргүүлэн ажиллаж, хүсэлт ирүүлсэн 6 аж ахуйн нэгж, байгууллагаас шаардлага хангасан "Рысжан" ХХК, Көшелик"ХХК, "Омар төрө" ХХКомпаниудад хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллав. Хөтөлбөрийн хүрээнд мэргэшсэн зөвлөх Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан дүрэм, журам, тушаал, хөдөлмөрийн гэрээ, аргачлал зэрэг ажил олгогчийн заавал тогтоох хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг боловсруулан өгч, хөдөлмөрийн харилцааны талаар ажил олгогчдыг арга зүйгээр ханган ажилласан. Хөдөлмөрийн харилцааны талаар нийт 16 удаагийн сургалт зохион байгуулж 628 хүнийг уг сургалтад хамруулсан бол, харилцааны чиглэлээр 269 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөв.	Хэрэгжсэн

3.2. 1.3.	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;		Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо	Хөдөлмөрийн маргаан зохицуулах асуудлын талаар 57 өргөдөл, гомдол хүлээн авч, 17 өргөдөл гомдлыг эвлэрүүлэн шийдвэрлэсэн.	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна.	Аймгийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд 95 иргэнээс гомдол ирсний 20 маргааныг эвлэрүүлэн ажиллаж, 6 гомдлыг гомдол гаргагч буцаан татсан бол 54 маргааныг гурван талт хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлж талууд эвлэрэх боломжгүй гэх үндэслэлээр шүүхээр шийдвэрлүүлэх шийдвэр гаргаж, 15 маргаан шийдвэрлэх шатанд явж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд тогтмол дэмжлэг үзүүлэн хуралдах орон байраар болон удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Энэ тоо өсөж байгаа нь улсын хэмжээнд явагдсан ажлын байрны цомхотголтой холбоотой байна.	Хэрэгжсэн
3.2. 1.4.	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах.		Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	5 хамтын гэрээ, 1 хамтын хэлэлцээрийг бүртгэсэн.	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна.	Аж ахуйн нэгж, байгууллагуудад хамтын гэрээ байгуулах талаар 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, шинээр 7 байгууллагын хамтын гэрээг хянан баталгаажуулж, 8 байгууллагын хамтын гэрээний хугацаа дуусгавар болсныг шинэчлэн байгуулж, хянан баталгаажуулж мэдээллийн санд бүртгэн ажиллав.	Хэрэгжсэн
3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:							

3.2. 2.1.	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;	3,412,337.30	1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо	2024 онд аймгийн хэмжээнд 137 аж ахуйн нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнээс тэргүүлэх салбар барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж ордог байна.	Судалгаа, шинжилгээн ий ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна	Баян-Өлгий аймгийн хэмжээнд 17 салбарын 144 аж ахуйн нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн онцлогоос хамарч барилгын салбарт 35, гурил, гурилан бүтээгдэхүүн 23, арьс шир 4, Ноос, ноолуур 12, Оёмол бүтээгдэхүүн 15, Хэвлэл 2, Дахин боловсруулах 3, Мод, модон эдлэл 15, Сүү, сүүн бүтээгдэхүүн 8, Мах, махан бүтээгдэхүүн 8, Согтууруулах ундаа 1, Ус, ундаа 2, Нөөшилсөн бүтээгдэхүүн /жимс, ногоо/ 2, фото үйлчилгээ 8 аж ахуйн нэгж үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Эдгээр байгууллагуудаас шаардлагатай дэмжлэгийн санал авахад ихэнх нь нийгмийн даатгалын шимтгэл багасгах, татварын хөнгөлөлт хөнгөлөлт үзүүлэх, бага хүүтэй зээлийг сангаар дамжуулан олгож байх талаар санал болгов.	Хэрэгжсэн
3.2. 2.2.	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;		Судалгаа, мэдээллийн тоо	2024 онд Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх ажлыг төлөвлөсөн боловч санхүүгийн байдлаар хийгдээгүй	Аймгийн /сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн	Аймгийн хэмжээний ажилгүй иргэдийн тоон судалгаанд хамрагдсан 10042 ажилгүй иргэдээс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа авах ажлын хэсэг байгуулагдан судалгаа хийв. Хэрэгцээний судалгааны үр дүнгээр 6287 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ шаардлагатай гэсэн тоон үзүүлэлт гарсан. Судалгаагаар тус аймагт ажиллах хүчний илүүдэл их байгаа бөгөөд ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 60 хувь нь боловсролын салбарт ажиллах сонирхолтой	Хэрэгжсэн

				сан үүссэн байна.	байгаа бол үлдсэн хувь нь бусад салбарт ажиллах сонирхолтой байна.	
3.2. 2.3.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2024 он - Ажиллах хүчний оролцооны түвшин аймгийн хэмжээнд 59%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.2%, ажилгүйдлийн түвшин 9.8%	Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Аймгийн хэмжээний ажилгүй иргэдийн судалгаагаар 10042 иргэн ажилгүй байна. Үүнээс 4789 нь эмэгтэйчүүд, 1118 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн насны бүлгээр авч үзвэл: 18-34 насны 5554 иргэн, 35-44 насны 2962 иргэн, 45-аас дээш насны 1526 иргэн байна. Судалгааны дүнгээр аймгийн төвийн сум болох Өлгий сумын хамгийн их ажилгүй иргэнтэй буюу 7282 иргэн нь ажилгүй байна. Ажилгүй иргэдийн 50-аас дээш хувь нь залуучууд эзэлж байгаа учраас Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Аймгийн ИТХ-ын 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 2026 оны аймгийн төсөвт 30.0 сая төгрөг батлуулж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Старт-ап арга хэмжээнд хамрагдах залуучуудад дэмжлэг үзүүлэх, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр бий болгоход орон нутгаас оролцоог хангаж дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон.	Хэрэгжсэн

<p>3.2. 2.4.</p>	<p>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;</p>		<p>1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ</p>	<p>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа хөдөлмөрийн насны 724 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулсан.</p>	<p>Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.</p>	<p>Аймгийн хэмжээнд ХНХСайдын 2021 оны 6 дугаар сарын 21-ны А/103 дугаар тушаалын дагуу “ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧИГ ОЛГОХ” журмыг үндэслэн 11 сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг зохион байгуулан ажилласан. Үүнд: 1182 өрхийн 6530 иргэн үүнээс насанд хүрсэн 3716 хүн, 2814 хүүхдийг ХЭБ-ийн үйлчилгээнд сар бүр хамруулан ажиллаж байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 11 сарын байдлаар 961.8 сая төгрөг зарцуулсан байна. “ХАЛАМЖААС- ХӨДӨЛМӨРТ” бодлогын хүрээнд нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнүүдэд хамруулан ажиллаж байна. Үүнд: - Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны 604 иргэн ажил хайгчийн бүртгэлд бүртгүүлэв. - Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад ХЭБҮ-нд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны 300 иргэнийг хамруулсан. - Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт ХЭБ-ийн үйлчилгээ авдаг 2 өрхийг хамруулсан. - Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 150 иргэнийг хамруулсан. - Хөдөлмөрийн чадвартай 312 иргэн мал маллаж хөдөлмөр эрхэлж байна. - Хууль сурталчлах өдөрлөгт оролцож ард, иргэдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний талаарх хууль, журмыг танилцуулан, зөвлөгөө өгч ажилласан. Баруун бүсийн “ХБИ-ийн хөдөлмөр</p>	<p>Хэрэгжсэн</p>
----------------------	--	--	--	--	--	--	------------------

					эрхлэлтийг дэмжих” хэлэлцүүлгийг тус аймагт зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцсон 250 гаруй ажилгүй иргэдэд нийгмийн халамжийн тухай хууль болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг сурталчлан, гарын авлага тарааж, зөвлөгөө өгч ажилласан. Дээрх арга хэмжээг авч ажилласнаар 2024 онд 1480 өрхийн 8113 хүн Нийгмийн халамжаас хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байсан бол 2025 онд 1182 өрхийн 6530 хүн болж 19.6 хувиар буурсан байна.		
3.2. 2.5.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх;		1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт 2. Холбогдох арга хэмжээний тоо	Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна.	Жоб центр туршилтын төслийг тус аймагт хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэх талаар ХХҮЕГазарт албан бичгээр санал хүргүүлэн харилцан санал солилцон ажиллаж байна.	Хэрэгжээгүй	
3.2. 2.6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон		1 Хяналт шалгалтын тоо 2. Судалгаа, мэдээллийн тоо 3. Холбогдох арга хэмжээний тоо	Газрын даргын баталсан удирдамжийн дагуу ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэдэд 2 удаа хяналт	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад 1 удаа, 8 сумаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэдээс түүврийн аргаар 130 иргэний ажлын байртай танилцаж, эргэн төлөлтийн нөхцөл байдалд давхардсан тоогоор 9 удаа хяналт-шалгалт хийлээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн	Хэрэгжсэн

	эсэхэд хяналт тавих;		тавьж ажилласан.	нэмэгдсэн байна.	төлөлтийг эрчимжүүлэх, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийн төлбөр барагдуулахад хяналт тавьж ажилласнаар доорх үр дүн гарсан. Найдваргүй авлагатай 14 иргэний 33.2 сая төгрөг байсан. Үүнээс сураггүй болсон 2 иргэний 4.1 сая, нас барсан 2 иргэний 3.6 сая төгрөг нийт 4 иргэний 7.7 сая төгрөг төлөгдсөн, бусад 10 иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлэх, нас барсан иргэдийн ар гэрт нь мэдэгдэж, хугацаа хэтэрсэн авлагыг 68% бууруулсан байна.	
3.2. 2.7.	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;	1 Холбогдох арга хэмжээний тоо 2 .Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент /шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо	ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 1 хүнийг хамруулж, 10.0 сая төгрөг зарцуулсан	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	Залуучуудын гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, ирээдүйтэй санааг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, санал санаачилгыг дэмжих зорилгоор Залуучуудын гарааны бизнесийг дэмжих шилдэг "Старт-ап" арга хэмжээг зохион байгуулав. Уг арга хэмжээний 1-р шатны сонгон шалгаруулалтад 25 баг, 52 залуучууд, 2-р шатанд 12 баг өрсөлдөж шилдэг бизнес санаа нь шалгарсан эхний 2 баг тус бүрд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 50 хувийг эргэн төлөгдөх нөхцөлтэй 15,0 сая төгрөг олгов. Арга хэмжээний хүрээнд 4 байнгын ажлын байр бий болсон.	Хэрэгжсэн

3.2. 2.8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах;		1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Хөдөлмөрийн яармагийг 2 удаа зохион байгуулж, 126 иргэнийг хамруулсан.	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг авсан иргэдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн яармаг 2025” өдөрлөг, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа, “Ability Expo” үзэсгэлэн худалдааг зохион байгуулав. Үзэсгэлэн худалдааг 3 удаа зохион байгуулахад ХЭДСангаас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан 201 хувиараа хөдөлмөр эрхлэгчид үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан оролцож, борлуулалт хийлээ.	Хэрэгжсэн
3.2. 2.9.	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Холбогдох арга хэмжээний тоо	ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 6.0 сая төгрөг зарцуулсан	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж 3 удаа хуралдуулан, зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу ажилласан. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх зорилго бүхий ажлын хэсгүүдэд зөвлөлийн гишүүдээс төлөөлөл оруулан хамтран ажиллалаа. Төрийн байгууллагуудад гарсан сул, чөлөөтэй, шинээр бий болсон ажлын байрны мэдээллийг хөдөлмөр зах зээлийн мэдээллийн санд бүртгэн, иргэдийг мэдээллээр ханган ажиллах зорилгоор Аймгийн Засаг дарга 2024 оны А/1112 захирамж гарсан. Тус захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн	Хэрэгжсэн

					бүх төрийн байгууллагуудын удирдлагуудыг оролцуулсан 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 164 байгууллагын удирдлагууд оролцож сул, чөлөөтэй, шинээр ажлын байр бий болсон тохиолдолд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт мэдэгдэж байх талаар хамтран ажиллах гэрээ байгуулав. Төрийн байгууллагуудаас ирүүлсэн 330 /байнгын 131, түр 199/ ажлын байрны захиалгыг хүлээн авч, олон нийтэд зарлаж, ажилгүй иргэдэд мэдээлэл өгч ажиллав. Ажлын байрны талаарх мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан И-жоб платформд бүртгэж, ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлан ажиллав.	
3.2. 2.10	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд	1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	ХЭДСанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуула агүйн төлбөрт 44.0 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн.	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасан заалтыг хэрэгжүүлэх хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 12 иргэнийг ажлын байранд зуучлан, хуулийг сурталчлан таниулах хүрээнд 6 удаагийн мэдээллийг бэлтгэн хүргэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй байгууллагуудын судалгааг гарган, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 6 байгууллагад төлбөр төлөх тухай албан бичиг хүргүүлэн ажилласнаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 32.4 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан.	Хэрэгжсэн

	зориулалтын дагуу зарцуулах.						
3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:							
3.2. 3.1.	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх.	2024 онд сургалт, сурталчилгааны ажлуудад 5.5 сая төгрөгийг зарцуулж 69 байгууллагын 1457 иргэнийг сургалтад хамруулан, 268 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан	Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна.	2025 оны байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаагүй ч аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нэг удаагийн арга хэмжээнд 3.2 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэн ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 189 хүнийг хамруулсан байна. Мөн Сагсай, Цэнгэл, Цагааннуур, Ногооннуур сумын 59 малчинд үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, байгалийн эрсдэлээс хамгаалах чиглэлээр 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлагаа хэвлүүлэн тараан ажилласан.	Хэрэгжсэн.

3.2. 3.2.	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Төлөвлөсөн төсөв 2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хувиараа хөдөлмөр эрхлэгч 120 иргэнийг, малчин өрхийн 52 иргэнийг сургалтад хамруулж, 35 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хувиараа хөдөлмөр эрхлэгч 101 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 47 ахмад, хувиараа хөдөлмөр эрхлэгч 41 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулав. Мөн Сагсай, Цэнгэл, Цагааннуур, Ногооннуур сумын 59 малчинд үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, байгалийн эрсдэлээс хамгаалах чиглэлээр 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлагаа хэвлүүлэн тараан ажилласан.	Хэрэгжсэн
3.2. 3.3.	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1 Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	Үйлдвэрлэлийн ослын 5 акт баталгаажуулсан, үйлдвэрлэлийн хурц хордлого гараагүй байна.	Тухай бүр арга хэмжээ авсан байх	2025 оны тайлант хугацаанд 6 ослыг судлан бүртгэсэн ба үүнд амь үрэгдсэн 2, хөнгөн, хүнд бэртэл гэмтэл авсан 4 ослыг баталгаажуулсан ба салбараар нь авч үзвэл боловсролын салбар 1, эрүүл мэндийн салбар 1, уул уурхайн салбар 2, барилгын салбар 2 байна. Баталгаажуулсан 6 үйлдвэрлэлийн ослыг inspection.hudulmur-halamj.gov.mn цахим бүртгэлийн системд бүртгэн мэдээллийн сан үүсгэлээ. Үйлдвэрлэлийн хурц хордлогын тохиолдол гараагүй байна.	Хэрэгжсэн
3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:							

3.2.4 1.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт	Гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авч ажиллуулж байгаа 6 аж ахуйн нэгж байгууллагуудад хамтран ажиллах гэрээ байгуулж, 14 иргэнийг ажлын байранд зуучлав. Гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авч ажиллуулж байгаа ЕБ-ын Емпати сургуульд 2, Жөн Юан ХХК-д 25, ЕБ-ын сургуулийн Зайд сургуульд 1, Угур ХХК-д 1, Азат ХХК-д 2, Норвегийн тусламжийн байгууллагад 3, Памуккале ХХК-д 2 гадаадын иргэн хөдөлмөр	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах хүсэлтэй 11 аж ахуйн нэгж, байгууллагын 406 ажлын байрны захиалгыг цаг тухайд нь И-жоб платформ нээлттэй байршуулан ажиллаж, тус аймагт гадаадын 92 иргэн хөдөлмөр эрхэлж байгаа болно.	Хэрэгжээгүй
	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал,	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр		сургуулийн Зайд сургуульд 1, Угур ХХК-д 1, Азат ХХК-д 2, Норвегийн тусламжийн байгууллагад 3, Памуккале ХХК-д 2 гадаадын иргэн хөдөлмөр	Хуулийн хэрэгжилт сайжирсан байна	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/16 дугаар удирдамжийн дагуу уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхэлж буй 3, барилгын салбарын 1 объектыг төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамруулсан ба 4 ААН-д нийт гадаадын 92 иргэн ажиллаж байна. Холбогдох хуулийн хэрэгжилт дунджаар 81.4% тай ба 3 аж ахуйн нэгжид зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн ба биелэлт 69.6%-тай байна.	Хэрэгжсэн
3.2.4.2.	хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.						

				эрхэлж байгаа ба нийт 36 гадаадын иргэд орон нутагт шилжин ирж ажиллаж байна.		
--	--	--	--	---	--	--

3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.

3.3.1. Нийгмийн даатгалын талаар:

	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын	1,660,685.50	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он- 152 800	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор албан бус хөдөлмөр эрхлэгч, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах зорилгоор Өлгий сумын 13 багийн иргэдэд сургалт зохион байгуулж, мөн иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, нийгмийн даатгалд хамрагдах хүсэлтэй иргэдтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллав. Сумын байцаагчид багийн иргэд, малчидтай уулзалт хийж сайн дурын даатгалын ач холбогдол, тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг улсын төсвөөс төлөх болсон талаарх шинээр орсон хуулийн заалтуудын талаар мэдээлэл	Хэрэгжсэн
--	--	--------------	--	--	---	--	-----------

	байгууллагатай хамтран зохион байгуулах;				хүргэн, малчны хотонд очиж иргэн бүртэй тулж ажилласан. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийн 50 хувийн шимтгэлийг тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил эрхлээгүй эх /эцэг/-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс төлөх шинэ хуулийн заалтын тухай сурталчлан таниулах ажлыг орон нутгийн радио, Дербес телевиз, цахим пейж хуудсаар тогтмол түгээдэг. Үр дүнд нь 0-3 хүртэл настай хүүхэдтэй эхийн сайн дурын даатгалд 1203 эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 160 эцэг, эх сайн дурын даатгалд хамрагдаж байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 1069 даатгуулагч хамруулж, сайн дурын даатгуулагчдын тоо өмнөх оноос 202 хүнээр нэмэгдэж Сайн дурын даатгуулагчдын тоо 4152 байна. Үүний 2019 нь малчид байна.	
3.3.1.2.	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	80%	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт	Нийт тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тоо 15118. Үүнээс өндөр настны тэтгэвэр авагч 7042, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагч 1462, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1331, цэргийн тэтгэвэр авагч 240 нийтдээ 10075 хувийн хэргийг 100% цахим хэлбэрт оруулсан болно.	Хэрэгжсэн

					шилжүүлсэн байна		
3.3. 1.3.	<p>Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;</p>		<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо 105</p>	<p>Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо -848</p>	0	<p>Нийгмийн даатгалын газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт 14 арга хэмжээ тусгаж биелэлтийг сар бүр дүгнэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахад аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, арилжааны банкнууд /ХААН, Төрийн банк, Голомт, Капитрон/-тай хамтран ажиллаж байна. Шинээр 105 байгууллагын 2140,5 сая төгрөгийн авлагыг Шүүхийн байгууллагад шилжүүлснээс 90 байгууллагын 1025,3 сая төгрөгийн авлага бүрэн барагдав. Хугацаа хэтэрсэн авлагатай 25 байгууллагын 787.3 сая төгрөгийн авлагыг ШШГГазарт хүргүүлж 23 байгууллагын 219.1 сая төгрөгийн авлагыг албадан барагдуулав. Оны эхэнд байсан ШШГГазарт байгаа 115.4 сая төгрөгийн өртэй 2 байгууллагын авлага барагдаагүй болно. Оны эхний нийт авлагын 83 хувь буюу 1213,2 сая төгрөгийн авлагыг барагдуулав. Үүнд он дамжсан 0-5000 төгрөгийн өртэй 36 байгууллагын 25100 төгрөгийн авлага бүрэн барагдсан. 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийн нийт авлагын хэмжээ 4226,7 сая төгрөг ба үүний 3350,6 сая төгрөг нь төсөвт байгууллагуудаас авах авлага байна.</p>	Хэрэгжсэн

3.3. 1.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;		Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 102446 Баян-Өлгий аймагт 4626	Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна.	Хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн тоо болон зонхилох шалтгаан болж буй 5 өвчний талаарх судалгааг сум, өрхөөр гаргасан бөгөөд албан бичгийн хамт Эрүүл мэндийн газар, бүх сумын эрүүл мэндийн байгууллага, аймгийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийж улсын дунджаас дээгүүр байгаа 4-өөс дээш хувьтай Алтай сум 4,7%, Алтанцөгц сум 4,3%, Булган сум 4,5%, Буянт сум 4,4%, Бугат сум 5,1%, Толбо сум 5.9%, Өлгий сум 4,3%-тай сумуудын хөдөлмөрийн чадвар алдсан иргэдтэй дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудтай танилцуулж, цаашид эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган, хөдөлмөрийн чадвараа алдалтаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2024 онд 4626 байсан бол 2025 онд 4670 болж өссөн үзүүлэлт нь амын тоо өссөн мөн өвчлөл өндөр байгаатай холбоотой байна.	Хэрэгжээгүй
3.3. 1.5.	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо	Орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс тус аймагт шинэ Өлгий суурьшлын бүсэд ирээдүйн амьдрах орчин, хот төлөвлөлтийн шинэ шийдэл болсон «2160 айлын цогцолбор хотхон»-ы ТЭЗҮндэслэл бүрэн хийгдэж, шав тавих ёслолыг 9 дүгээр сард хийсэн. Тус цогцолбор хотхонд 640 хүүхдийн 2 ерөнхий боловсролын сургууль, 240 хүүхдийн 2 цэцэрлэг, 50 ортой оношилгоо-эмчилгээний төвтэйгээр	Хэрэгжсэн

					судалгаатай болсон байна.	төлөвлөгдсөн ба 3-5 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжих юм. Тус хотхоныг байгуулах төслийг хэрэгжүүлэгч компани зүгээс 24 айлын орон сууцыг 100 хувийн хөнгөлөлттэйгөөр зорилтот бүлгийн иргэдэд олгохоор шийдвэрлэсэн.	
3.3.2. Нийгмийн халамжийн талаар:							
3.3. 2.1.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо		Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	Орон нутгийн 2025 оны төсвөөс олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийт 149.0 сая төгрөг батлагдсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/35, А/53 дугаар тушаалуудын дагуу энэхүү үйлчилгээг иргэн, төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх зохицуулалттай тул аймгийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран 2025 оны 6 дугаар сард 4 багцаар нээлттэй тендер зарлаж, сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийн үр дүнд 2 багцад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны Баян-Өлгий аймаг дахь Хүүхэд-хөгжил холбоо” болон “Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн Баян-Өлгий аймаг дахь хороо” төрийн бус байгууллагууд шалгарч, 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “ХБХЭЭХолбооны Баян-Өлгий аймаг дахь Хүүхэд хөгжил холбоо” ТББ нь 11.9 сая төгрөгийн үйлчилгээ, Баян-Өлгий аймгийн Улаан Загалмайн хороо нь 50.9 сая, нийт 62.8 сая төгрөгийн үйлчилгээг тус тус үзүүлсэн байна. Тус хугацаанд зорилтот бүлгийн нийт 185 иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэн ажилласан	Хэрэгжсэн

					байна. Аймгийн ШШГГазартай хамтран архи, согтууруулах ундаа хэрэглэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхээр баривчлагдсан иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухаанд сургах сургалтыг тогтмол зохион явуулж 396 хүнийг хамруулсан байна.	
3.3. 2.2.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	2025 оны жилийн эцсийн байдлаар архинд донтож удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2 иргэнийг донтолтоос ангижруулах эмчилгээнд хамруулсан байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Сэтгэц, наркологын тасагт 7 иргэнийг эмчлүүлэн 1 иргэнийг түр ажлын байранд холбон зуучилж ажлын байртай болгох арга хэмжээ авсан байна.	Хэрэгжсэн
3.3. 2.3.	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах.	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1. Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 2. сургалтын тоо	Нийгмийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна.	Сумын Халамжийн мэргэжилтнүүд Хамтарсан багийн гишүүний хувьд Монголын мэргэжлийн нийгмийн ажилтны нийгэмлэг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хамтарсан "Чадавхжуулах сургалт"-д оролцсон. Орон нутагт ажиллаж байгаа Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажилласнаар 684 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрсдэл өндөр 114 тохиолдолд кейс нээж хариу арга хэмжээ авах ажилд хамтран ажилласан байна. Хамтарсан багийн нийгмийн ажилтнууд хамтран 16 удаагийн сургалтыг зохион байгуулж хүүхэд хамгаалал, халамж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	Хэрэгжсэн

чиглэлээр мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан байна.

3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:

3.3. 3.1.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Сургалт	12	30-аас доошгүй	<p>Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 4 удаагийн сургалт, 2 удаагийн хэлэлцүүлэг, 1 удаагийн уулзалт, 2 удаагийн арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулж, 1162 иргэнийг хамруулсан байна. 2025 оныг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" баруун бүсийн цогц арга хэмжээг зохион байгуулав. Цогц арга хэмжээний үеэр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, сэргээн засах тусламж үйлчилгээ хүргэх, зөвлөгөө өгөх, Протез, ортопед, тусгай хэрэгслийн зөвлөгөө өгөх, захиалга авах ажлыг зохион байгуулж, алслагдсан сумууд болох Ногооннуур, Толбо сумууд мөн Өлгий сумын нийт 160 иргэнд Протез, ортопед, тусгай хэрэгслийг нийгмийн халамжийн сангийн хөнгөлөлтөөр хамруулж олгосон. Мөн "ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ" аймгийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 600 иргэнийг мэдээ, мэдээллээр ханган ажиллахаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан 110 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурал 7 хоног болгон тогтмол хуралдаж,</p>	Хэрэгжсэн
--------------	--	---------------------------------	---------	----	----------------	--	-----------

						хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хүндрэл, бэрхшээлгүй, түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Хуралд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн тухай хууль болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн талаар, хөнгөлөлт, тусламжид хэрхэн хамрагдах талаар тогтмол мэдээ мэдээлэл өгч ажилласан.	
3.3. 3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	8	20	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 2 удаагийн хэлэлцүүлэг, 12 удаагийн сургалт, 1 удаагийн уулзалт, аян, 2 удаагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 1162 иргэнийг хамруулсан байна. Орон нутгийн радиогоор 2 удаагийн ярилцлага өгч, ард иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх журмыг брошур, тараах материалыг казах, монгол хэлээр хэвлүүлэн 462 иргэнд тараан ажилласан байна. Орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ЭРХ, ХАМГААЛАЛ, ОРОЛЦООГ хангах чиглэлээр орон нутгийн бодлого шийдвэрт тусгах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодит болгож, зоригтой өөрчлөлт хийцгээе” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн газар ХГБХХГазар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн	Хэрэгжсэн

						бус байгууллагууд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид, иргэдийн төлөөлөл, нийт 200 гаруй иргэн оролцсон болно. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанд оруулан тус зөвлөлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	
3.3. 3.3.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Зохион байгуулсан сургалтын тоо	0	3	"Бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх" V аяны хүрээнд зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан болон орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан орлогоо нэмэгдүүлэх арга зүй, мэдлэг, ур чадвар олгох сургалтыг аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэс болон Мобиком корпорац ХХК-тай хамтран 3 удаа зохион байгууллаа. Сургалтын зорилго нь хиймэл оюун ухааныг ашиглан цахим ур чадвараа хөгжүүлэх, өөрөө өөртөө ажлын байр бий болгох, нэмэлт орлоготой болох боломжийг нэмэгдүүлэхэд оршлоо. Тус сургалтад нийгмийн халамжийн үйлчилгээ авч буй 150 гаруй иргэн хамрагдсан бөгөөд сургалтын үеэр холбогдох байгууллагуудын албан хаагчид мэдээлэл өгч, нийгмийн халамжийн хүрээнд үзүүлж буй хөнгөлөлт, тусламжийн талаар гарын авлага тараалаа.	Хэрэгжсэн

3.3. 3.4.	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх Дэмжих төвийг байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Дэмжих төв	0	1	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх Дэмжих төв байгуулагдаагүй боловч олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоотой хамтарч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон сэтгэл зүйг дэмжих сургалтыг жилийн турш 12 удаа зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн авьяас чадварыг илрүүлэх зорилгоор гар зураг болон шатар дам, хэл заслын сургалтуудыг сард 2 удаа тогтмол зохион байгуулж, 60 хүүхдийг хамруулсан. Хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор хөдөлгөөн заслын болон сэргээн засах үйлчилгээнд 120 хүүхдийг хамруулсан байна.	Хэрэгжээгүй
3.3. 3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо		2	Хэрэгжсэн	

						сая төгрөг шийдвэрлэж тоног төхөөрөмж, хурлын ширээ сандлаар ханган ажилласан.	
3.3. 3.6.	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь		100	Тус аймагт "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг аймгийн төвийн 54 байгууллагыг хамруулан 6 дугаар сард зохион байгуулсан. Мөн 10 сум, 1 тосгонд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулснаар аймаг, сум бүрийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, бүх шатны байгууллагын бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлсэн юм. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудын төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг хамгаалах тодорхой зорилтуудыг тусгахаас гадна аюулгүй байдлын талбайг нэмэгдүүлж иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлуудыг хийж гүйцэтгэв.	Хэрэгжсэн
3.3. 3.7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	5	Аймгийн хэмжээнд Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн 115 хүүхэд байгаа. Тус хүүхдүүдийг асран хамгаалж байгаа асран хамгаалагч нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн асаргаа сувилгаа үзүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо, Норвегийн	Хэрэгжсэн

	болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх					тусламжийн байгууллага, Бөхөн уул сүлжээ төрийн бус байгууллагуудтай хамтран 10 удаа зохион явуулж давхардсан тоогоор 280 хүн хамрагдсан болно.	
3.3. 3.8.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	1	3	Аймгийн Засаг даргын 2024 оны 1112 дугаар захирамж гарч Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөхийг бүх аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг болгосон. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн бүх төрийн байгууллагуудын дарга нарт 2 өдрийн сургалт зохион байгуулж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдээллээр хангаж ажилласан. Аймгийн хэмжээний 25 ба түүнээс дээш ажилтантай байгууллагуудад давхардсан тоогоор 10 удаагийн үзлэг зохион байгуулав. Үзлэгт 72 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 8 байгууллагын төлбөр болох 38.2 сая төгрөгийн төлбөрийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн ажиллав. Дээрх үйл ажиллагааг Норвегийн тусламжийн байгууллагын Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах төсөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах "Бөхөн уул" сүлжээ төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн.	Хэрэгжсэн

3.3. 3.9.	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	3	5	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг "Дербес" телевизтэй хамтын ажиллагааны гэрээ хийж төрийн байгууллагуудаас зохион байгуулж буй үйл ажиллагаануудыг цаг тухайд нь иргэд, олон нийтэд хүргэхээс гадна төрийн захиргааны бүх байгууллагууд өөрийн цахим хуудсаа тогтмол хөтөлж цаг үеийн мэдээ мэдээллийг байрлуулан олон нийтэд хүргэж байгаа. Түүнчлэн аймгийн олон нийтийн радиогоор цаг үеийн мэдээ мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд хүргэж ажилласан. Тус аймагт "Шугыла" сэтгүүл, "Дербес" телевиз, Олон нийтийн радио, төрийн захиргааны 4 байгууллага олон нийтэд хүртээмжтэй веб хуудастай байна.	Хэрэгжсэн
3.3. 3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85	90	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл 2025 онд хоёр удаа хуралдаж 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан жилийн турш хэрэгжүүлэн ажилласан. Салбан зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж нийт 3.1 сая төгрөг зарцуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг шийдвэрлэгдсэн. Тус санхүүжилтээр салбар комиссын үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах, хамтын ажиллагааг сайжруулах, цахим үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэн тоног төхөөрөмжөөр ханган ажилласан.	Хэрэгжсэн

	ажиллагааг сайжруулах;							
3.3. 3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв.	0	3	Аймгийн ХХҮГазар болон ХГБХХГазар нь төрийн үйлчилгээний Нэгдсэн төвд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг барилга нь 2023 онд ашиглалтад орсон иргэдэд ээлтэй, дээд давхар луу тохируулгатай цахилгаан шатаар гарах бүрэн боломжтой байгууламж юм. Нийгмийн даатгалын газар 2 давхар барилгын 1 давхарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдүүлэн иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгыг хүртээмжтэй болгох үүднээс ариун цэврийн өрөөнүүдэд нь засвар үйлчилгээ хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саадгүй хүлээн авах боломжтой болгосон.	Хэрэгжсэн	
3.3. 3.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.		Хөгжлийн төвийн тоо	0	1	Аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулах асуудлыг аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд төрийн албан хаагчидтай хийсэн ажил хэрэгч уулзалтын үеэр аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулах шаардлагатай байгаа талаар танилцуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг санал болгосон. Тус аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулагдаагүй боловч 2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих баруун бүсийн цогц арга хэмжээг зохион байгуулж энэ үеэр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сэргээн засах тусламж үйлчилгээ хүргэх, зөвлөгөө	Хэрэгжээгүй	

					<p>өгөх, Протез, ортопед, тусгай хэрэгслийн зөвлөгөө өгөх, захиалга авах ажлыг зохион байгуулж, алслагдсан сумууд болох Ногооннуур, Толбо сумууд мөн Өлгий сумын нийт 160 иргэнд Протез, ортопед, тусгай хэрэгслийг нийгмийн халамжийн сангийн хөнгөлөлтөөр олгосон.</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх цахим бүртгэлд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авдаг нийт 1878 иргэнээс 1050 иргэнийг хамруулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал, хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаанд хамруулан ажиллав.</p> <p>-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоотой хамтарч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хууль эрх зүйн болон сэтгэл зүйг дэмжих сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 35 эцэг эх хамрагдаж, мэдээлэл солилцлоо.</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор гар зураг болон шатар даам, хэл заслын сургалтад давхардсан тоогоор 38 хүүхдийг, хөдөлгөөн засал болон сэргээн засах үйлчилгээнд 36 хүүхдийг хамруулан ажилласан.</p>
--	--	--	--	--	---

3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:

<p>3.3. 4.1</p>	<p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.</p>	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгө өр</p>	<p>1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо</p>	<p>3</p>	<p>5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.</p>	<p>Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх үүднээс дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. - Байгууллагын Эцэг эхийн зөвлөлүүдтэй хамтран Гэр бүлийн боловсрол олгох сургалтуудыг тогтмол зохион явуулж, нийт 61 байгууллагын 3386 хүнийг хамруулсан байна. - Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран гэр бүлийн амгалан тайван байдал алдагдуулсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүлжүүлэгдсэн иргэдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтыг долоо хоног 2 удаа тогтмол зохион байгуулж байгаа. Уг арга хэмжээнд нийт 396 хүн хамрагдсан. - “Хос багана” хосуудын уулзалт арга хэмжээ, Цэргийн баярын өдрийг тохиолдуулан “Эрчүүдийн яриа” уулзалт, зорилтот өрхийн гишүүдийг хамруулсан “Өөрийгөө хайрлахуй” уулзалт, “Гэр бүлийн хөгжилд бидний оролцоо” уулзалт, залуу гэр бүлийн гишүүдэд зориулсан “Гэр бүлээрээ гэрэлтэй” уулзалт, “Жендерийн тухай ойлголт”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг”, “Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалал”, “Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга” сургалтууд, Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Хөгжлийн ялгаатай хүүхдийг ойлгох нь”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Гэр бүлийн соёл-Нийгмийн баялаг” зэрэг сургалтуудыг зохион байгуулж нийт 1394 хүнийг хамруулсан. - Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 250 ш зөвлөмжийг</p>	<p>Хэрэгжсэн</p>
---------------------	---	--	---	----------	--	--	------------------

						<p>шинээр гэр бүл болсон залуучуудад гэр бүлийн баталгаа авах үеэр тараах ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Гэр бүлийн боловсрол олгох зорилго бүхий нөлөөллийн 15 төрлийн постер, 9 төрлийн контент бэлтгэн байгууллагын цахим хуудсаар түгээн ажилласан байна. Нийт хандалтын тоо 45851 байна.</p>	
3.3.5. Ахмад настны талаар:							
3.3. 5 1	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил	2	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна.	<p>Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийг олон нийтэд сурталчлах зорилгоор Аймгийн олон нийтийн Радиогоор 3 удаагийн ярилцлага, "Дербес" телевизээр 1 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн хүргэхээс гадна 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 120 хүнийг хамруулсан байна. Сумын Ахмадын салбар хороогоор дамжуулан хуулийг сурталчлах 13 удаагийн уулзалтыг тухай орон нутгийн ахмадуудыг хамруулан зохион байгуулж хуулийг сурталчлан ажилласан. Уг арга хэмжээнд нийт 160 хүнийг хамруулсан байна.</p> <p>Ахмад настуудын Баруун бүсийн зөвлөгөөнийг 6 дугаар сард амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийт 120 ахмадуудыг хамруулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.</p>	Хэрэгжсэн

3.3. 5.2.	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо 32	ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна.	Аймгийн хэмжээнд Ахмадын сан байгуулсан 51 байгууллага, аж ахуйн нэгж байгаа бөгөөд 300.0 мянгаас 8.0 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтийг санд төвлөрүүлэн ахмадуудын сайн сайхан байдлын төлөө зарцуулж байна. Түүнчлэн аймгийн Засаг даргын албан даалгавар гаргаж бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн ахмадын сантай болох, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Тус аймагт тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байгаа 6 байгууллага байна.	Хэрэгжсэн
3.3. 5.3.	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.ҮЙЛЧИЛГЭЭНД хамрагдсан ахмад настны тоо	Нийт ахмадын 60%	20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна.	2025 оны байдлаар Баян-Өлгий аймагт ахмадын 1 Ордон /аймгийн төвд/, сумуудад ахмадын 4 өргөө, ажиллаж байгаа бол 7 сум ахмадын танхимтай байна. Аймгийн Ахмадын хорооны үйл ажиллагааны зардал болон Ордны урсгал зардалд орон нутгийн төсвөөс 100.0 сая төгрөгийн батлан үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Аймгийн төвийн сумаас бусад 12 сумын Ахмадын салбар хороодын үйл ажиллагаанд сум, орон нутгийн төсвөөс 500.0 мянгаас 4.0 сая хүртэлх төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар Ахмадуудад зориулагдсан Ордон, өргөө, танхимаар давхардсан тоогоор 6300 ахмад үйлчилгээ хүртсэн байгаа нь нийт ахмадуудын 63 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн

3.3. 5.4	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Үйлчилгээн Д хамрагдсан тоо	3800	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээг аймгийн Ахмадын Ордноор дамжуулан хэрэгжүүлж чийрэгжүүлэлтийн танхим, биллиардын өрөө, бүжгийн танхим тохижуулан ажиллуулахаас гадна аймгийн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай гэрээ байгуулан 7 хоногт 2 удаа зааланд ахмадуудыг үнэгүй үйлчлүүлэх боломжоор ханган ажиллаж байна. Ахмад настнуудын идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд давхардсан тоогоор 4200 ахмад хамрагдсан байна.	Хэрэгжсэн
3.3. 5.5.	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	0	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна	Ахмад настнуудын нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг аймгийн Ахмадын Хороо болон сумдын ахмадын хороодоор дамжуулан хэрэгжүүлж байна. Тус үнэлгээнд 1200 ахмад настныг хамруулан тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Ахмад настнуудын бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүйн байдлыг нь дэмжих үүднээс Ахмадын Ордонд бүжгээр хичээллүүлэх, гар бөмбөг, шатар, биллиард тоглуулах, урлагийн арга хэмжээнд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.	Хэрэгжсэн

3.3. 5.6	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	0	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг аймгийн Засаг даргын 2025 оны А/636 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна. Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг хуралдаж ахмад настны цогц үнэлгээ хийх ажлын зохион байгуулалттай холбоотой тодорхой шийдвэрүүдийг гаргаж Ахмадын хороогоор дамжуулан цогц үнэлгээ хийж ажлыг зохион байгуулсан.	Хэрэгжсэн
3.3. 5.7.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн	25	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд Ахмадын Хорооноос санаачлан 54 ахмад настан төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн салбарын 25 байгууллагад ажиллаж туршлагаа хуваалцах, сургалт хийх, зөвлөн туслах үйлчилгээг явуулсан байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүүхэд хамгааллын салбарын 35 байгууллагад 67 ахмад настан зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	Хэрэгжсэн

	ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;		ахмад настны тоо				
3.3. 5.8.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1 Журам баталсан эсэх 2. Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	0	Журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмын төслийг боловсруулан бэлэн болгосон. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дараагийн хуралдаанд оруулан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Хэрэгжээгүй

3.3. 5.9.	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна." гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих;</p>	<p>50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо</p>	<p>Суурь түвшний тоо 0</p>	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна</p>	<p>50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настан авч ажиллах тухай хуулийн заалтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилгаа явуулсны үр дүнд 10 аж ахуйн нэгж ахмад настныг ажлын байраар ханган ажиллаж байна.</p>	<p>Хэрэгжсэн</p>
--------------	---	--	----------------------------	--	---	------------------

3.3. 5.10	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.	Орон нутгийн төсвийн хөрөнгө өр	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	0	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллага байхгүй байна.	Хэрэгжээгүй
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ							88.2%

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЕРГЕН

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ВИТА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

К.ЗАНГАР

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Е.ЗАНГАР

